



ТАЙЛАНГИЙН АГУУЛГА

1. Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүн:	2
1.1 БИЕИЙН ТАМИР СПОРТЫН ТУХАЙ ХУУЛЬ, КОРОНАВИРУСТ ХАЛДВАР /КОВИД-19/-ЫН ЦАР ТАХЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ТЭМЦЭХ, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ	2
1.2 МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР	3
1.3 НИЙСЛЭЛИЙН болон ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР	6
• СПОРТЫН ТЭМЦЭЭН УРАЛДААН	12
2. Тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, үр дүн	14
2.1. ХУУЛЬ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ	14
2.2 ЗОРИЛТОТ ЖИЛИЙН ХҮРЭЭНД ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖИЛ	14
3. Байгууллагын үйл ажиллагааны үр дүн	15
3.1. БАЙГУУЛЛАГЫН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ	15
3.2. ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО - Хэрэгжилт	15
3.3. АРХИВ АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТ, АЛБАН БИЧИГ, ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭН АЖИЛЛАСАН АЖЛЫН ХЭРЭГЖИЛТ	15
3.4. БАЙГУУЛЛАГЫН ӨМЧ, САНХҮҮГИЙН ТАЛААР	16
3.5. ТӨРИЙН БОЛОН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГААС ЗОХИОН БАЙГУУЛСАН СУРГАЛТУУДАД ХАМРАГДСАН БАЙДАЛ	16
4. Байгууллагын ил тод байдал:	17
4.1. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ	17
4.2. ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО	21
5. Бусад:	24
5.1. БУСАД БАЙГУУЛЛАГУУДАЙ ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААН	24



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ 2021 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

2021 оны 11 дүгээр сарын 01

Улаанбаатар хот

1. Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүн:

1.1 БИЕЙН ТАМИР СПОРТЫН ТУХАЙ ХУУЛЬ, КОРОНАВИРУСТ ХАЛДВАР /КОВИД-19/-ЫН ЦАР ТАХЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ТЭМЦЭХ, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ

Хуулийн -13.2.1 заалтын хүрээнд:

Монгол Улсын засгийн газрын 2021 оны 45 дугаар тогтоолын дагуу гарсан Улсын Онцгой комиссын 2021 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн “Түр журам, заавар батлах тухай” 18 дугаар тушаалын хэрэгжилтийн хүрээнд Дүүргийн нутаг дэвсгэрт үйлчилгээ явуулж буй Биеийн тамир, спорт, чийрэгжүүлэх, бялдаржуулах төв, төрөлжсөн спорт клуб, спорт заал, спорт талбайн үйлчилгээ үйл ажиллагаанд 2021 оны 2 дугаар сарын 25-аас үргэлжлүүлэн 61 аж ахуйн нэгжид хяналт тавин ажилаад байна. Биеийн тамир спортын улсын хороо мөн Нийслэлийн захирагчийн албанд өдөр бүр мэдээ өгч, үүрэг чиглэлийг хэрэгжүүлнэ ажиллаа.



Коронавируст халдвар /ковид-19/ цар тахлын хариу арга хэмжээ авч ажиллах ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын шийдвэрээр аж ахуйн нэгжүүд Нийслэлийн спорт хороотой хариуцлагын гэрээ байгуулан түүнд тавигдах тусгай нөхцөл шаардлагыг хангаж ажиллахаар болсон. Үүний дагуу Нийслэлийн спорт хорооны даргатай Баянзүрх дүүргийн 21 аж ахуйн нэгж хариуцлагын гэрээ байгууллаа.

Хариуцлагын гэрээний дагуу дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Биеийн тамир, спорт, чийрэгжүүлэх, бялдаржуулах төв, төрөлжсөн спорт клуб, спорт заалны үйлчилгээ үйл ажиллагаанд тавигдах тусгай нөхцөл шаардлага"-ын хэрэгжилтийг хангуулах зорилгоор 2021 оны 9 дүгээр сарын 02 - 11 дүгээр сарын 30-ныг хүртэл 30 аж ахуйн нэгжид хяналт шалгалт хийхэд 110 ажилтан, албан хаагч нийт 1305 хүнд үйлчилсэн байна. Хяналт шалгалтын явцад 1 усан бассейн сургалтын төв хариуцлагын гэрээ



хийгээгүй үйл ажиллагаа явуулж байсныг зөвлөгөө өгч, анхааруулан сануулга өгч ажиллав. Нийслэлийн захирагчийн албанд 7 хоног бүр мэдээ өгч, үүрэг чиглэлийг хэрэгжүүлнэ ажиллаа. 2021 оны 09 дүгээр сарын 13-аас 11-р сарын 30-ныг хүртэл Пүрэв гараг бүр хариуцлагын гэрээний мэдээг Нийслэлийн биеийн тамир, спортын хороонд хүргүүлэн ажиллаж байна.

- Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын улсын хорооны даргын А/225 дугаар тушаалын хавсралт короновируст халдвар /ковид-19/ цар тахлын үед гадаа талбайд зохион байгуулах спортын тэмцээний үйл ажиллагаанд баримтлан ажиллах ерөнхий удирдамжийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор 2021 оны 08 дугаар сарын 02-ны өдрөөс 11 дүгээр сарын 30-ны өдрүүдэд иргэдийн очих дуртай, бөөгнөрөл үүсгэж болзошгүй нийтийн эзэмшлийн 5 гадаа талбайд 20 удаагийн хяналт шалгалт хийхэд олон нийтийн үйл ажиллагаа зохион байгуулсан 2 зөрчил илэрч, зохион байгуулсан болон хорооны Засаг даргад сануулга өгч, анхаарч ажиллах тал дээр зөвлөгөө өглөө.



-Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газраас чиглэл өгсөний дагуу 7 дугаар хорооны 147 өрхийн Коронавируст цар тахлын батлагдсан тохиолдлуудын гэрээр эмчлүүлж байгаа иргэн, тэдгээрийн ойрын хавьтал болсон, эмнэлэг рүү шилжүүлсэн мэдээлэл, урьдчилан сэргийлэх, халдварын эрсдэлийг бууруулах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний дагуу иргэдтэй утсаар холбогдож зөвлөгөө өгч ажиллаа.

1.2 МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

2.2.1. Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах зан төлөвт насан туршийн дадал олгох зорилго бүхий биеийн тамир, спортын хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан нээлттэй, уян хатан тогтолцоог үндэсний хэмжээнд бүрдүүлнэ.

- 2021 оны жилийн эцсийн байдлаар Нийтийн биеийн тамирын 5 цахим арга хэмжээ зохион байгуулж 35 байгууллагын 25230 иргэн хамрагдсан байна.



- Дүүргийн иргэдийн спортын наадмыг 2021 оны 12 сарын 04-12-ны өдрүүдэд спортын 4 төрлөөр зохион байгууллаа. Тус наадамд 28 хорооны нийт 1300 иргэн хамрагдах юм.

Шинэ короно вирус халдварт өвчин гарч олон нийтийн арга хэмжээ тэмцээн уралдаан зохион байгуулах боломжгүй болсон тул арга хэмжээ тодорхойгүй хугацаагаар хойшлогдоод байна. Биеийн тамир спортын хорооны ажилтан албан хаагчид халдварт бус өвчинөөс урьдчилан сэргийлэх, мөн дасгал хөдөлгөөнөөр эрүүлжих, дархлаажих, алхалт, гүйлтийн ач холбогдол зэрэг 5 нэр төрлийн 1200 гаруй гарын авлага хэвлэн иргэдэд тараасан. Мөн социал фэйсбүүк хуудас вэйб сайтаар дамжуулан иргэдэд халдварт бус



өвчинөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж гарын авлагыг хүргэн ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд 300 гаруй хүнд хүрсэн үзүүлэлттэй байна.

- Коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, ажилтан, албан хаагчид гэрээсээ онлайнаар байгууллагын хэвийн үйл ажиллагааг ханган ажиллах, гэртээ хийж болох дархлаа дэмжих, дасгал хөдөлгөөнийг гэрээр видео бичлэг хийнэ дүрсжүүлж иргэдэд хүргэх, түгээх, хөдөлгөөний хомсдлоос урьдчилан сэргийлэх зорилгоор Нийслэлийн Спортын хороо - Баянзүрх дүүргийн Биеийн тамир, спортын хорооноос зохион байгуулсан "Идэвхтэй хөдөлгөөнд-Иргэн бүр" аяны хүрээнд волейбол, гимнастик, иогийн гэртээ хийж болох энгийн дасгалуудийг хийж, сошиал нүүр хуудсанд тухай бүрд постлож, Ковид-19 цар тахлын талаарх мэдээ, мэдээллийг тогтмол сошиал хуудсаар дамжуулан ажиллаа. Иргэдэд болон ЗД-н дэргэдэх өсвөрийн шигшээ багийн тамирчдад зориулан дархлаа дэмжих 26 дасгал хичээл, ӨШБ-ийн тамирчдад 42 удаагийн цахим хичээл бэлтгэн цахим орчинд явуулсан ба 9927 хандалт авч ойролцоогоор 29000 орчим хүнд хүрсэн байна. Цахим хичээлүүдийг Спорт хороо Баянзүрх гэсэн фэйс хуудас болон , www.bzd.sport.gov.mn вэйб сайтаар түгээлээ.



Баянзүрх дүүргийн нийт биеийн тамирын багш нарын дунд "ДАСГАЛ ХИЙЖ ДАРХЛААГАА ДЭМЖИЕ - ӨӨРӨӨ ХИЙЖ БУСДЫГ ДАГУУЛЬЯ" уриалгатай CHALLENGE-ийг цахимаар амжилттай зохион байгууллаа. Тус арга хэмжээнд 15 сургуулийн биеийн тамирын багш нар оролцож байгууллагын фэйсбүүк хуудсаар видео контент оруулж хүүхдүүдийг дасгал хөдөлгөөн хийхийг уриаллаа. Тус видео контентуудийг 3212 хүн үзэж 680 хүнд таалагдаж 218 хүн share хийж бусдад хуваалцлаа.





2.2.2.Монгол үндэсний уламжлалт спортыг дэлхий нийтэд таниулахад төрөөс бодлогоор дэмжиж, үндэсний спортын төв байгуулж, гадаад улсын баг тамирчдыг оролцуулах тэмцээн, наадмын тогтолцоог хөгжүүлнэ.

Үндэсний спортын өв соёлыг түгээн дэлгэрүүлэх, дэмжих зорилгоор Үндэсний бөхийн дүүргийн аварга шалгаруулах тэмцээнийг цэцэрлэгийн насны ангиллаар 2 удаа, өсвөр залуучуудын насаар 1 удаа, ЕБС-н багш нарын дунд 1 удаа зохион байгуулахаар төлөвлөснөөс:

2021 оны өсвөр үе, залуучуудын УАШТ-нд оролцох баг тамирчдыг сонгон шалгаруулах сорилго барилдааныг өсвөр үеийн 3 нас, залуучуудын 2 насны ангиллаар 2021 оны 11-р сарын 07-ны өдөр зохион байгууллаа. Тэмцээнд өсвөр үеийн 46 бөх, залуучуудын 22 бөх тойргийн барилдаанаар хурд, хүч авхаалж самбаагаа сорин өрсөлдлөө.Нас тус бүрд түрүүлсэн тамирчидыг Өсвөр үе, Залуучуудын Улсын аварга шалгаруулах тэмцээнд Баянзүрх дүүргээс оролцох эрхээр батламжлав.

- 16-нас Э.Жавхлантөгс
- 17-нас Б.Сундуйжав
- 18-нас Н.Амгаланбаатар
- 19-нас Б.Амарбаясгалан
- 20-нас М.Баяржавхлан / аймгийн начин / зэрэг тамирчид нас болгондоо түрүүлж УАШТ-нд Баянзүрх дүүргийг төлөөлөн орох эрхийг авлаа.

Үндэсний бөхийн өсвөр үе, залуучуудын **Улсын аварга шалгаруулах тэмцээн** 4 өдрийн турш Улаанбаатар хот, Монгол бөхийн өргөөнд өсвөр үе 16, 17, 18 нас, залуучууд 19,20 насны ангиллаар явагдаж дүнгээ гаргаж, аваргуудаа тодрууллаа. 21 аймаг 9 дүүргээс шалгарсан нийт 151 залуучууд, өсвөр үеийн шилдэгүүд хүч үзсэнээс Баянзүрх дүүргийн баг тамирчид амжилттай оролцлоо.

Залуучуудын ангилалд:

М.Баяржавхлан тэргүүн байранд шалгарч залуучуудын Улсын аварга боллоо / БЗД-Алдар спорт хороо /

Б.Амарбаясгалан шагналт байранд шалгарч амжилттай оролцлоо / БЗД-Даян бөхийн дэвжээ /

Өсвөр үеийн ангилалд:

Том нас буюу 18 насанд Н.Амгаланбаатар 28 даваатай дэд байранд шалгарлаа /БЗД-48-р сургууль/

Дунд нас буюу 17 насанд

Б.Сундуйжав амжилттай оролцож шагналт байранд шалгарлаа / БЗД-Даян бөхийн дэвжээ /

Бага нас буюу 16 насанд

Э.Жавхлантөгс амжилттай оролцож шагналт 5-р байранд шалгарлаа /БЗД-ӨҮШБТ/ Өсвөр үеийн багийн дүнгээр:

О.Түмэнжаргал ахлагчтай Г.Энхбаяр / МУГД/ М.Амаржаргал, Б.Самбууням дасгалжуулагчтай Баянзүрх Дүүргийн баг тамирчид тэргүүлж 2021 оны Үндэсний бөхийн өсвөр үеийн Улсын аварга баг боллоо.





Баянзүрх дүүргийн Шагайн харвааны Г.Гантулга ахлагчтай баг тамирчд, болон П.Хүдэрчулуун, Б.Амарсайхан ахлагчтай Үндэсний сурын харвааны баг тамирчдын бэлтгэл сургуулилтыг дэмжин хамтран ажиллаж байна.

Нийслэлийн аварга шалгаруулах шагайн харвааны тэмцээнд Баянзүрх дүүргээс 2 багийн 8 тамирчин амжилттай оролцлоо. **1-р байранд** Ж.Бүрнээ ахлагчтай Баянзүрх дүүрэг, **2-р байранд** Д.Нямдалай ахлагчтай Багануур, **3-р байранд** Б.Дэмбэрэлтулга ахлагчтай Чингэлтэй дүүрэг, **4-р байранд** Г.Гантулга ахлагчтай Баянзүрх дүүрэг харваачид тус тус эзэллээ.



1.3 НИЙСЛЭЛИЙН болон ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

Монгол улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.3.дахь “Иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт талбайн хүртээмжийг нэмэгдүүлж, олон улсын жишигт нийцсэн спортын барилга байгууламжийг барина”.

-НЗД-ын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.3.2 заалт, Баянзүрх дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1 заалтын дагуу дүүргийн спорт цогцолборуудыг ашиглалтанд оруулна ажлын хүрээнд:

-Баянзүрх дүүргийн биеийн тамир спорт цогцолборын барилгын гүйцэтгэгч “Атимос трейд” ХХК нь 2017 онд 731.5 сая төгрөгийн санхүүжилт авч, барилга гүйцэтгэлийн тайлангаа БСШУСЯ-д дүгнүүлэн үргэлжлүүлэн гүйцэтгэхээр гэрээгээ сунган барилгын ажлаа эхлүүлээд байна. Барилын явц 85%-ийн гүйцэтгэлтэй гадна пассад дулааны ажлыг зургийн дагуу хийж гүйцэтгэж байгаа бөгөөд 2019 оны 3 улиралд ашиглалтанд оруулахаар төлөвлөсөн боловч санхүүжилт байхгүйн улмаас барилгын ажил түр зогсоод байна. Спортын ордоны барилгын ажлын явцтай УИХ-ын Ц. Мөнхцэцэг, Ж. Чинбүрэн болон Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны ажлын хэсгийн гишүүд, ЗГТА-БТСУХ-ны дарга Ц.Шаравжамц тэргүүтэй албаны төлөөлөгчид газар дээр нь очиж танилцлаа.





-НЗД-ын үйл ажиллагааы хөтөлбөрийн 2.2.3.5 заалт, Баянзүрх дүүргийн Засаг даргын үйл ажиллагааы хөтөлбөрийн 2.1.5 заалтын Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааг удирдлагаар ханган дэмжлэг үзүүлнэ ажлын хүрээнд:

-Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2017 оны 07 дугаар сарын 06-нд батлагдан 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байгаа ба тус шинэчилсэн найруулгын дагуу дүүргийн Засаг даргын 2018 оны 02 сарын 05-ны өдрийн А/ЗЗ тоот захирамжаар Өсвөрийн шигшээ багийн тоог 12-т хүргэн шинэчлэн байгуулж үйл ажиллагааг тасралтгүй явуулж байна.

-Өсвөрийн шигшээ багийн багш дасгалжуулагчдын жилийн төлөвлөгөөг, уралдаан тэмцээнд оролцох хуваарь, тухайн жилд зарцуулах төсвийн саналыг авч, батлагдсан төлөвлөгөөний дагуу бэлтгэл сургуулилтанд хамруулах ажлыг зохион байгуулдаг. Өсвөрийн шигшээ багийн 12 төрөлд нийт 1000 гаруй тамирчин хүүхэд хичээллэж байгаа бөгөөд үүнээс 192 тамирчинг Дүүргийн аварга шалгаруулах тэмцээн болон бусад шатны уралдаан тэмцээнээс сонгон шалгаруулж бүртгэн авч хичээллүүлэх ба өсвөрийн шигшээ багийн 12 спортын төрлөөр дүүргийн аварга шалгаруулах тэмцээн явуулахаар төлөвлөсөн.

Эдгээрээс: Жү-до бөх-28, Самбо бөх-23, Чөлөөт бөх-28, Бокс-13, Тэшүүр-6, Спортын гимнастик-9, Волейбол-28, Ширээний теннис-10, Даам-10, Сагсан бөмбөг-22, Буудлага-7, Байт харваа-8 нийт 192 тамирчин тус тус бэлтгэл сургуулилтад хамрагдана.

Короно вирусын халдварын хөл хорио нээгдсэнээр шигшээ багуудын бэлтгэл сургуулалт хэвийн үйл ажиллагаанд орон явагдаж байсан ба дахин хөл хорио зарлагдсаны улмаас төлөвлөсөн уралдаан тэмцээн, бэлтгэл сургуулалт бүгд тодорхойгүй хугацаагаар хойшлогдсоор байна.

Хөл хорионы үед өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах зорилгоор цахим хичээлийн хуваарь гарган спортын төрөл хариуцсан багш нараар онлайн хичээл зохион байгуулж байгаа нь цаг үеэ олсон, үр дүнгээ өгсөн ажил боллоо.

Оны сүүлчээр явагдсан Улсын аварга шалгаруулах тэмцээнээс Өсвөрийн шигшээ багийн Жү-до бөх, Чөлөөт бөхийн тамирчид **алт-1, мөнгө-2, хүрэл-5 нийт 8 медаль** хүртлээ.

-НЗД-ын Засаг даргын үйл ажиллагааы хөтөлбөрийн 2.2.1.4 заалт, Баянзүрх дүүргийн Засаг даргын үйл ажиллагааы хөтөлбөрийн 2.2.2 заалтын дагуу Иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн биеийн тамирын үйл ажиллагааг өргөжүүлж, нийтийг хамарсан томоохон арга хэмжээнүүдийг зохион байгуулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ ажлын хүрээнд:

Дүүргийн хэмжээнд биеийн тамир, чийрэгжүүлэлтийн ажлыг тогтмолжуулан иргэд, ажилтан албан хаагчдын бие бялдрын боловсрол, соёлыг дээшлүүлж хөдөлгөөний хомсдлоос урьдчилан сэргийлэхэд мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг улам сайжруулж, тэднийг биеийн тамир, спортын арга хэмжээ, уралдаан тэмцээнд идэвхтэй оролцуулах биеийн тамир, спортын дасгал хөдөлгөөний ач холбогдол, чийрэгжүүлэлтийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор Эрүүл мэндийн нэгдэлтэй хамтран дүүргийн харьяа хэлтэс албадын ажилтан албан хаагчдын дунд ажлын байрны сургалтыг зохион байгуулж ажиллаж байна.

Төрийн болон төрийн бус байгууллагууд мөн ААН-үүдтэй хамтран ажиллаж БТСХ-ны зүгээс болон тэдгээр байгууллагуудын санаачлагаар зохион байгуулж байгаа нийтийг хамарсан спортын арга хэмжээг зохион байгуулахад мэргэжил арга зүйн зөвлөгөөг тогтмол хүргэж хэвшсэн.

Ковид-19 ийн эсрэг “Идэвхитэй хөдөлгөөнд – Иргэн бүр” уриан дор нэгдэцгээе арга хэмжээнд сургуулийн өмнөх болон цэцэрлэгийн насны хүүхдүүд, өсвөр үе, хүүхэд залуучуудад, ахмадууд зориулсан нийт 26 дасгал видео бичлэгээр сошиал хуудсаар дамжуулна



Баянзүрхийн гүйгчид-2021 >

Public group · 214 Members



+ Invite



хүргэж 8207 хандалт авсан байна.

-Улс орон даяар зохион байгуулагдсан биеийн дархлааг дэмжих “**Эрүүл мэндийн цахим гүйлт-2021**” арга хэмжээг 2021 оны 03 дугаар сарын 15-28-ны хооронд дүүргийн хэмжээнд зохион байгууллаа.

Цахим гүйлтэд оролцогчид нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн “Strava” аппликейшныг ашиглаж тэмцээнд оролцоно. Дүүрэг “нэг баг” гэсэн зохион байгуулалтаар ажиллаж байна. Тус гүйлтэд хэрхэн оролцох талаа зөвлөгөө, зөвлөмжийг холбогдох мэргэжилтнүүд өөрөө болон байгууллагын фэйсбүүк хуудас болон вэйб сайтаар дамжуулан хүргэн ажиллаж байна. Баянзүрх дүүрэг “НЭГ дүүрэг НЭГ баг” гэсэн зохион байгуулалтаар оролцож “Strava” аппликейшн дээр 448 гишүүнтэй нийт 16,836 км зам туулсан амжилттайгаар 9 дүүргийн хэмжээнд эхний 2-р байранд орлоо. Дүүргээ төлөөлөн гадаадад амьдарч байгаа Баянзүрх дүүргийн уугуул иргэд идэвхи санаачлага гарган оролцлоо.

Туршлагатай гүйгч Л.Дамдинсүрэн 14 хоногийн хугацаанд 1027,1 км гүйсэн амжилтаар улсанд тэргүүлсэн сайхан амжилт гаргалаа. Дүүргийн хэмжээнд амжилт гарган эхний 3 байр эзэлсэн, тусгай байр эзэлсэн оролцогчдод батламж, медаль гардууллаа.



- **"Дасгал хөдөлгөөн хийцгээ" цахим арга хэмжээ**

ЗГХА-БТСУХ-ны даргын 2021 оны 05 сарын 20-ны өдрийн А/150 тоот тушаалаар батлагдсан "Идэвхтэй хөдөлгөөнийг дэмжих сарын аян" арга хэмжээ 06 сарын 02-30-ны хугацаанд зохион байгуулагдлаа.

Энэхүү арга хэмжээг дүүргийн хэмжээнд зохион байгуулахаар дүүргийн Засаг даргын 2021 оны 06 сарын 02-ны өдрийн А/262 тоот захирамж гаргуулж, салбар хороог өргөн бүрэлдэхүүнтэй батлуулсан. Уг арга хэмжээний "Алхалт-гүйлт, дугуй" цахим уралдааныг мөн "Strava" аппликейшнээр зохион байгуулж байгаа ба одоогоор 541 гишүүнтэйгээр 14 хоногийн хугацаанд дүүргийн нийт 604 оролцогчид алхалт гүйлээр 8145 км замыг, дугуйгаар 3835 замыг туулсан амжилттай оролцлоо. Биеийн тамир, спортын хороо тухайн гүйлтийн талаар 4 удаа байгууллагын хурал хийж цахим гүйлтийн арга хэмжээг дүүргэт зохион байгуулах ажлын хэсэгт үүрэг даалгавар өглөө.





Баянзүрх дүүрэгээ төлөөлөн бусдыгаа манлайлан идэвхи зүтгэл гарган амжилттай оролцож хамгийн хол зам туулсан эрэгтэй, эмэгтэй гүйгчдийн эхний 3 байр, сельфи



уралдааны эрэгтэй, эмэгтэй 1-р байрт өргөмжлөл, медаль, мөнгөн шагналаар шагнах тухай гэрээг ЗГТА-БТСУХ байгуулж шагналыг гардууллаа.

Арга хэмжээнд оролцож буй гүйгчдийн нэгдсэн Спорт хороо Баянзүрх фэйсбүүк хуудсаараа дамжуулан Л.Дамдинсүрэн, залуу гүйгчдийн төлөөлөл Д.Гантулга нартай хамтран ажиллаж мэдээлэл солилцож, бусдыгаа уриалан оролцох, идэвхжүүллээ. Мөн социал хуудсаар 25 пост оруулан нийт 2000 гаруй хүн үзсэн байна.



Байгууллагын мэргэжилтнүүдэс гадна залуу гүйгч Д.Гантулгийг цахим админаар томилон ажиллуулсан нь маш үр дүнтэй байлаа.

Арга хэмжээнд оролцож эхний байр эзэлсэн хүмүүсийн 40% гадаад улсаас дүүргээ төлөөлөн оролцсон оролцогчид байлаа.

-Шинэ короно вирус халдварт өвчин гарч олон нийтийн арга хэмжээ, тэмцээн уралдааныг заал талбайд зохион байгуулах боломжгүй болсон тул хүлээгдэж байна.

“Цахим гимнастрада” биеийн тамирын арга хэмжээ

Дэлхий нийтээрээ Коронавируст цар тахлыг даван туулахаар тэмцэж байгаа энэ үед иргэд, олон нийтийг идэвхтэй хөдөлгөөнд уриалж, дархлаагаа дэмжин дасгал хөдөлгөөнөөр хичээллэх боломж олгож энэхүү арга хэмжээг зохион байгуулсанд иргэд, олон нийт талархана хүлээн авч, амжилттай оролцлоо.

“Цахим гимнастрада” биеийн тамирын арга хэмжээ 2021 оны 10-р сарын 15-аас 2021 оны 11 дүгээр сарын 21-ны өдрүүдэд 21 аймаг, 9 дүүргийн хэмжээнд зохион байгуулагдлаа.

“Цахим гимнастрада” биеийн тамирын арга хэмжээний цахим сургалтыг 10-р сарын 18-аас 10-р сарын 22-ны өдрүүдэд Засгийн газрын тохируулагч агентлаг – Биеийн тамир, спортын улсын хороо, Нийслэлийн биеийн тамир, спортын хорооноос хамтран зохион байгууллаа. Цахим сургалтанд Баянзүрх дүүргийн цэцэрлэг, сургууль, хэлтэс албадын нийт 28 байгууллагын 31 хүн хамрагдаж дасгалын тайлбар, амьсгаа авалт, хэмнэл, давталт, хөдөлгөөний зөв гүйцэтгэлийн талаар мэдээлэл авлаа. Тус арга ихэмжээнд 800 гаруй хүн оролцлоо.

“Цахим гимнастрада” биеийн тамирын арга хэмжээний хүрээнд баянзүрх дүүргийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулиуд, хэлтэс, албадуудад удирдамж, албан бичигийг хүргүүлж ажиллаа. Мөн фэйсбүүк хуудас, вэб сайтаар дамжуулна олон нийтэд сурталчилна, түгээх ажлыг зохион байгууллаа.

Баянзүрх дүүрэгт “Цахим гимнастрада” биеийн тамирын арга хэмжээг 2021 оны 10-р сарын 15-аас 2021 оны 11 дүгээр сарын 21-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулж 32 байгууллагын / цэцэрлэг, сургууль, хэлтэс албад/ нийт 90 дасгалыг албаны и-мэйл хаягаар хүлээн авч, тусгай серверт байршуулж, Засгийн газрын тохируулагч агентлаг –



Биеийн тамир, спортын улсын хороонд баянзүрх дүүргээс оролцсон багуудын дасгалын тоон мэдээллийн хамт хүргүүлээ. Мөн нийт дасгалын бичлэгийг фэйсбүүк хуудсандаа байршуулна ажиллаа.

Цахим гимнастрада арга хэмжээний дасгалын бичлэгийг сошиал фэйсбүүк хуудсаараа дамжуулна постлож нийт 90 бичлэгийг 28500 хүн үзэж, 6100 like авсан хандалттай байна.



Цахим гүлтийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээн

“Үндэстнээрээ нэг баг болон гүйцгээе” уриан дор уг арга хэмжээг улс орон даяар 2021 оны 09 сарын 10-с 10 сарын 10-д зохион байгуулагдлаа. Тус арга хэмжээг Strava апп ашиглан зохион байгуулагдсан ба дүүргээ төлөөлөн оролцох тамирчдад хэрхэн оролцох, гүйлтээ тооцуулах сургалт заавар зөвлөгөөг цахимаар болон биечлэн өгч оролцууллаа. Баянзүрх дүүргээс ойролцоогоор тогтмол гүйж хэвшсэн 50 гүйгч оролцсон ба Л.Дамдинсүрэн, Д.Баатархүү, Ш.Батсүх нар уламжлал ёсоор манлайлан оролцлоо. Монгол улсын баг тамирчид дэлхийд 3-р байр эзэлсэн сайхан амжилт гаргалаа.



Баянзүрх дүүргийн “ИРГЭДИЙН НААДАМ-21” Биеийн тамирын арга хэмжээ

- ЗГТА-БТСУХ-с ирүүлсэн нэгдсэн удирдамжын дагуу, дүүргийн Засаг даргын захирамж гаргуулан 2021 оны 12 сарын 04-12-ныг хүртлэх хугацаанд Баянзүрх дүүргийн “Иргэдийн наадам-21” Биеийн тамирын арга хэмжээний хүрээнд Олс таталт, Волейбол, Сагсан бөмбөг, Ширээний шагайн төрлүүдээр дүүргийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгууллаа.

1. Волейболын тэмцээнд- 14 хорооны 260 иргэн



2. Сагсан бөмбөгийн тэмцээнд -19 хорооны 325 иргэн
3. Олс таталтын тэмцээнд – 16 хорооны 128 иргэн
4. Шагайн наадгайн тэмцээнд - 8 хорооны 120 иргэн Нийт: **833** иргэн хамрагдлаа.

Волейболын тэмцээн:

Эрэгтэй

- 1-р байр 6-р хороо
- 2-р байр 23-р хороо
- 3-р байр 13-р хороо

Эмэгтэй

- 1-р байр 18-р хороо
- 2-р байр 8-р хороо
- 3-р байр 4-р хороо



"Олс таталт"-ын тэмцээн:

- 1-р байр 27-р хороо
- 2-р байр 17-р хороо
- 3-р байр 19-р хороо



Сагсан бөмбөгийн тэмцээн:

Эрэгтэй:

1. 23-р хороо
2. 27-р хороо
3. 12-р байр

Эмэгтэй:

- 16-р хороо
- 19-р хороо
- 26-р хороо



Ширээний шагайн наадгайн тэмцээн:

Эрэгтэй

1-р байр 27-р хороо
2-р байр 12-р хороо
3-р байр 23-р хороо

Эмэгтэй

1-р байр 12-р хороо
2-р байр 23-р хороо
3-р байр 14-р хороо



СПОРТЫН ТЭМЦЭЭН УРАЛДААН

-НЗД-ын Засаг даргын үйл ажиллагааг хөтөлбөрийн 2.2.1.5 заалт - “Өвлийн улиралд зохион байгуулах биеийн тамир, спортын үйл ажиллагааг өрөгжүүлнэ”, 2.2.2.1, 2.2.2.2 заалтууд, Баянзүрх дүүргийн Засаг даргын үйл ажиллагааг хөтөлбөрийн 2.2.3 заалт- “Спортыг дэмжих замаар өсвөрийн хүүхэд, багачуудыг биеийн тамир, спортын үйл ажиллагаанд оролцох оролцоог нэмэгдүүлнэ” ажлын хүрээнд:

Засгийн газрын тогтоол, Улсын онцгой комиссийн шийдвэрээр улбар шар бүсэд шилжсэнтэй холбоотойгоор “Ковид-19” цар тахлын хорио цээрийн хүрээнд зохион байгуулахаар төлөвлөж байсан дүүргийн аварга шалгаруулах спортын уралдаан тэмцээн бүрэн явагдаагүй болно.

Улсын аварга шалгаруулах тэмцээн:

Жүдо бөхийн **Өсвөр үеийн Улсын аварга** шалгаруулах тэмцээн 2021 оны 11-р сарын 12-14-ний өдрүүдэд “Сонгино хайрхан дүүргийн Биеийн, тамир спортын” зааланд амжилттай зохион байгуулагдлаа. Тус тэмцээнд 21 аймаг, 9 дүүрэг, 32 байгууллагийн нийт



325 Жүдоч 14 жингийн ангилалд хурд, хүч, авхаалж самбаагаа сорисноос Баянзүрх дүүргийн Засаг Даргын дэргэдэх өсвөр үеийн шигшээ багийн тамирчид 3-н хүрэл медаль хүртэж амжилттай оролцлоо.

- А.Таван-Эрдэнэ 60кг хүрэл медаль
- С.Азбаяр 70 кг хүрэл медаль
- О.Эрдэнэбаяр 65 кг хүрэл медаль тус тус хүртлээ.

Жүдо бөхийн **Залуучуудын Улсын аварга** шалгаруулах тэмцээн 2021 оны 11-р сарын 20,21-ний өдрүүдэд Спортын төв ордон “А” зааланд амжилттай зохион байгуулагдлаа. Тус тэмцээнд 42 баг эрэгтэй, эмэгтэй нийт 126 Жүдоч 14 жингийн ангилалд хурд, хүч, авхаалж самбаагаа сорисноос Баянзүрх дүүргийн Засаг Даргын дэргэдэх өсвөр үе,залуучуудын шигшээ багийн тамирчид алтан медаль-1, мөнгөн медаль-2, хүрэл медаль-1, багийн дүнгээр гутгаар байр эзэлж амжилттай оролцлоо.

- Л.Анхзаяа 73 кг алтан медаль
- Б.Нармандах 73 кг мөнгөн медаль
- Н.Мягмардорж 66 кг мөнгөн медаль
- Г.Болор-Очир 81 кг хүрэл медаль тус тус хүртлээ.



Чөлөөт бөхийн залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээн 2021 оны 11 сарын 22-д зохион байгуулагдаж эмэгтэй 76 кг-д Г.Дэлгэрцэцэг хүрэл медаль, Г.Содбаясгалан 5-р байр эзэллээ.



-Монголын Кураш бөхийн холбоо, Бүстэй барилдааны холбоотой хамтран улсын аварга шалгаруулах тэмцийг 4 насны ангиллаар 2021он 12 сарын 16-20-ниы өдрүүдэд “Аварга” БТДС дээр зохион байгуулахаар бэлтгэл ажлаа хангаад байна.



2. Тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, үр дүн

2.1. ХУУЛЬ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

Байгууллагын хэмжээнд 2021 оны жилийн эцсийн байдлаар доорх тогтоол, шийдвэрүүдийг хэрэгжүүлж байна. Үүнд:

1. Биеийн тамир, спортын тухай хууль
2. МУЗГ-ын тогтоол -№ 335 “Цогц хөтөлбөр батлах тухай”
3. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг - № 53 “Нийтийн Биеийн тамир, спортыг хөгжүүлэх тухай”
4. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг - №144 Багийн спортын талаар
5. МУЗГ-ын тогтоол - №05 “Нийтийн Биеийн тамир, спортын талаар авах зарим арга хэмжээ”
6. МУЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр
7. МУЗГ-ын тогтоол - №289 “Халдварт бус өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай”
8. Нийслэлийн ЗД-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр
9. Дүүргийн ЗД-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр
10. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2020 оны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 10 дугаар зарлиг/шинэ короно вирусас сэргийлэх тухай/

МУЗГ-ын 2021 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 45 тоот тогтоол, УОК-ын 2021 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн “Түр журам, заавар батлах тухай” 18 дугаар тушаал, ЗГТА-БТСГ-ын даргын А/21 тоот тушаал, НЗД-ын А/108, А/103, А/161... тоот захирамжууд.

- Албан хэрэг хөтлөлтийн www.edoc.ub.gov.mn програмын ашиглах, www.Archivedoc.mn Цахим архивын зааврыг хэрэгжүүлэх, Өргөдөл гомдлын www.smartcity.mn програмын ашиглан ажиллаж байна.

2.2 ЗОРИЛТОТ ЖИЛИЙН ХҮРЭЭНД ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖИЛ

- ✚ 2021 оныг Баянзүрх дүүргээс “Дэмжих жил” болгон зарласантай холбоотойгоор биеийн тамир спортыг дэмжин ажиллах талаар саналаа хүргүүлээд байна.

- ✚ “Хоггүй дүүрэг болгоё” хаврын их цэвэрлэгээ

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2021 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн А/01 дүгээр тушаал дүүргийн Засаг даргын “Хоггүй дүүрэг болгоё” хаврын их цэвэрлэгээ зохион байгуулах тухай А/226 дугаар захирамжийн дагуу “Баянзүрх дүүргийн Биеийн Тамир Спортын Хорооны нийт албан хаагчид 3-р хороотой хамтарч “ Хоггүй бол ГОЁ” уриа доор Хаврын Их Цэвэрлэгээний ажил дүүргийн хэмжээнд 5-р сарын 22,23-ны өдрүүдэд зохион байгуулагдлаа. 5-р сарын 22-ны өдөр Баянзүрх дүүргийн 3-р хорооны талбайд нээлтийн үйл ажиллагаа зохион байгуулж хорооны иргэдээ цэвэрлэгээний үйл ажиллагаанд хамтран ажиллаж идэвхитэй оролцохыг уриалан ажиллалаа. 3-р хорооны нутаг дэвсгэрт үүссэн хуурай хог болон гудамж талбайн хогийг 5 удаагийн ачилтаар нийт 15 тонн орчим хог хаягдлыг хогийн цэгрүү тээвэрлэн хүргүүллээ.





3. Байгууллагын үйл ажиллагааны үр дүн

3.1. БАЙГУУЛЛАГЫН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ

- ✚ Байгууллагын үйл ажиллагааны 2020-2024 онд хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулан батлуулсан ба 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Засгийн Газрын Тохируулагч Агентлаг-Биеийн Тамир Спортын Улсын Хорооны дарга Ц.Шаравжамц болон Баянзүрх дүүргийн Засаг дарга Н.Баярмөнх нараар батлууллаа.
- ✚ ЗГТА-БТСУХ-ны даргын 2020 оны 12 сарын 18-ний өдрийн А/98 тушаалын 2-р хавсралтын дагуу Баянзүрх дүүргийн биеийн тамир, спортын хорооны “Биеийн тамир спортын цахим сан” бүрдүүлэх ажлыг амжилттай зохион байгуулж цахим мэдээлийн санг бий болгон хөгжүүлэх <https://bzd.sport.gov.mn> сайттай боллоо. Иргэдэд байгууллагын хийж хэрэгжүүлж буй ажлыг сурталчилах, нийтийн биеийн тамир болон спортын арга хэмжээ, сургалтын талаар тухайн сайт болон фэйсбүүк хуудсаар дамжуулан мэдээлэн ажиллаж байна.
- ✚ Байгууллагын дэргэд орон тооны бус ББНШК, Өмч хамгаалах байнгын зөвлөл байгуулагдан ажиллаж байна.
- ✚ Захиргааны байгууллагын статистик мэдээг салбарын байгууллагуудаас авч нэгтгэн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг – Биеийн тамир, спортын газар, Нийслэлийн нийтийн БТСГ-т хүргүүлж ажилласан.
- ✚ Мөн төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлийг тайлан авах маягтын дагуу гаргаж Төрийн албаны зөвлөлд хүргүүллээ.

3.2. ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО - Хэрэгжилт

- ✚ Байгууллага нь 2021 оны эцсийн байдлаар Дарга, ахлах мэргэжилтэн-Чөлөөт бөхийн дасгалжуулагч, нягтлан бодогч-архив бичиг хэрэг, нийтийн биеийн тамир хариуцсан мэргэжилтэн-үйлчлэгч, спорт хариуцсан мэргэжилтэн, дасгалжуулагч гэсэн 7 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байна.
- ✚ Ажилтан, албан хаагчдын төрийн албаны ангилал, зэрэглэл, цалин урамшууллын өөрчлөлтийг тухай бүрт нь <https://hr.csc.gov.mn> сайтад шивж оруулан ажилласан.
- ✚ Тус байгууллагын ХАСХОМ гаргах 1 албан тушаалтан 2020 оны 02 дугаар сарын 15-с өмнө мэдүүлэг болон тайлангаа гарган НЗДТГ-н ТЗУХ-т хүргүүлж ажилласан.
- ✚ Салбарын бүтцийн өөрчлөлт хийгэж эхлээд байна.

3.3. АРХИВ АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТ, АЛБАН БИЧИГ, ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭН АЖИЛЛАСАН АЖЛЫН ХЭРЭГЖИЛТ

- ✚ Байгууллагын албан хаагчид <https://erp.ulaanbaatar.mn> болон <https://edoc.ulaanbaatar.mn> албан хэрэг хөтлөлтийн програмыг тогтмол ашиглан ажиллаж байна.
- ✚ 2021 оны жилийн эцсийн байдлаар албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн <https://edoc.ulaanbaatar.mn> систем буюу цахим хаягаар ирсэн албан бичиг 63, шийдвэрлэлт - 100 хувьтай, 38–н албан бичгийг албан байгууллага, аж ахуйн нэгжид явуулсан байна.
- ✚ Байгууллагын даргын үндсэн үйл ажиллагааны чиглэлээр буюу А тушаал 4, хүний нөөцийн чиглэлээр буюу Б тушаал 5 гаргаж, үйл ажиллагааг бүрэн зохион байгуулж тушаалын хэрэгжилт 100%-тай хэрэгжсэн байна.
- ✚ Байгууллагын үйл ажиллагааны явцад үүссэн 2020 оны архивын баримтыг цахим архивын програмд шилжүүлсэн.
- ✚ 2020 онд үүссэн захирамжлалын баримт бичиг байгууллагын даргын А тушаал 48, Б тушаал 17 ширхэгийг архивын цахим програмд шивж оруулсан байна.
- ✚ Мөн 2020 онд үүссэн байнга хадгалах 25 ширхэг, түр хадгалах 28 ширхэг, 70 жил хадгалах 4 ширхэг хадгаламжийн нэгжийг тус тус шалган хүлээн авч, байгууллагын дэргэдэх ББНШК-ын хурлаар оруулан баталгаажуулан архивт нөхөн бүрдүүлэлт хийсэн байна.



3.4. БАЙГУУЛЛАГЫН ӨМЧ, САНХҮҮГИЙН ТАЛААР

- ✚ Улсын төсвөөр 2021 онд нийтдээ 182601300 төгрөг батлагдсан ба эхний 9 сарын байдлаар 141004300 төгрөг санхүүжихээр батлагдсан байна.
- ✚ Орон нутгийн төсвөөс 2021 онд нийтдээ 20270200 төгрөг батлагдсан ба эхний 9 сарын байдлаар 18662000 төгрөг санхүүжихээр батлагдсан байна.

Үүнээс:

Биеийн тамир, спортын арга хэмжээнд 10 000 000 төгрөг
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулалд 104 605 600 төгрөг
Ажил олгогчоос нийгмийн даатгалын даатгалд төлөх шимтгэл 15 622 700 төгрөг
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 14 162 000 төгрөг
Хангамж, бараа материалын зардал 2 938 000
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 3 950 000
Эд хогшил, урсгал засварын зардалд 4 500 000
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх 1 348 000
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал 740 000
Бараа үйлчилгээний бусад зардал 2 100 000

- ✚ Байгууллагын мэдээллийн самбарт байршуулах, шилэн дансны хуулийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу шилэн дансны <https://shilendans.gov.mn>, <https://shilendans.ub.gov.mn> сайтуудад байгууллагын 2021 оны жилийн төсөв, 2020 оны санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, дараа оны төсвийн төсөл, төсвийн гүйцэтгэлийн 1,2,3 -р сарын мэдээ, цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын гүйлгээг мэдээллийг самбарт байршуулсан.
- ✚ Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгал, ашгийн орлогын, албан татварын тооцоо тайланг цаг хугацаанд нь гарган ажиллаж байна.
- ✚ Байгууллагын төсвийг нэмэгдүүлэх, уралдаан, тэмцээн, арга хэмжээний үр өгөөжийг дээшлүүлэх зорилгоор төрийн болон төрийн бус байгууллагуудтай арга хэмжээг удирдлага, зохион байгуулалт, хөрөнгө, санхүү, материаллаг баазын хувьд хамтран ажиллаж байна.
- ✚ Мөн үргүй зардлыг багасгах, төсвийн хөрөнгийн ашиглалт, зарцуулалтанд тавих хяналтыг өндөржүүлж, төсвийн сахилгыг мөрдлөгө болгон ажиллаж байна.

3.5. ТӨРИЙН БОЛОН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГААС ЗОХИОН БАЙГУУЛСАН СУРГАЛТУУДАД ХАМРАГДСАН БАЙДАЛ

1. Байгууллагын албан хаагч нар Ковидын нөхцөл байдлын хүрээнд дээд газраас зохион байгуулсан 19 удаагийн цахим хурал зөвлөгөөн, сургалтанд хамрагдсан ба байгууллагын хүрээнд 7 удаа цахим хурал зохион байгууллаа.
2. ЗГТА-Биеийн тамир спортын улсын хорооноос зохион байгуулсан “Биеийн тамир спортын санхүүгийн болон бүтэцийн шинэтгэл” сэдэвт сургалтад байгууллагын удирдлага, нягтлан нар оролцлоо.





4. Байгууллагын ил тод байдал:

4.1. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
Нэг. Үйл ажиллагааны ил тод байдал			
1.	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байршуулан тухай бүр шинэчлэх.	Биеийн тамир спортын хорооноос зохион байгуулах бүхийл арга хэмжээний байгууллагын даргаар батлагдсан удирдамж, заавар, холбогдох мэдээ мэдээллийг байгууллагын www.facebook.com/Спорт хороо Баянзүрх нүүр хуудас болон https://www.bzd.sport.gov.mn вэйб сайтад байршуулдаг ба тус хуудаснаас бүх байгууллагууд болон хороод мэдээллээ бүрэн авч хамтран ажиллаж байна.	90%
Хоёр. Шилэн данс			
1.	Шилэн дансны мэдээлэл оруулах	Монгол Улсын Шилэн дансны тухай хууль тогтоомжид заасан хуваарийн дагуу оруулбал зохих мэдээллүүдийг цаг хугацаанд нь оруулсан. Үүнд: 1. “Бүтэн жилээр оруулах мэдээлэл”-ээс: - 01-р сарын 10-ны дотор оруулах шаардлагатай “Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл”, “Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө” бүлгүүдийн “ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТЕНДЕР, ХУДАЛДАН АВАЛТ” төрөлд “ОРУУЛАХ МЭДЭЭЛЭЛ БАЙХГҮЙ” гэсэн мэдээлэл оруулсан. - 01-р сарын 16-ны дотор оруулах шаардлагатай “Байгууллагын батлагдсан төсөв” бүлгийн “ТӨСӨВ/ГҮЙЦЭТГЭЛ” төрөлд 202 871,5 мянган төгрөгийн төсвийн мэдээлэл оруулсан. 2. “Улирал бүр оруулах мэдээлэл”-ээс: - “Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт” бүлгийн “ТӨСӨВ/ГҮЙЦЭТГЭЛ” төрөлд 3. “Сар бүр оруулах мэдээлэл”-ээс: - “Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл” бүлгийн “ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТЕНДЕР,	



		<p>ХУДАЛДАН АВАЛТ” төрөлд, “Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт” бүлгийн “БУСАД” төрөлд 1, 2,3,4,5,6,7,8, дугаар саруудад “ОРУУЛАХ МЭДЭЭЛЭЛ БАЙХГҮЙ” гэсэн мэдээлэл оруулсан.</p> <p>- “Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт” бүлгийн “ТӨСӨВ/ГҮЙЦЭТГЭЛ” төрөлд 1, 2,3,4,5 ,6,7,8 дугаар саруудын мэдээг заасан хуваарийн дагуу дараа сарын 08-ны дотор оруулсан.</p> <p>“Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн жилийн батлагдсан төсөвт 202 871 500 төг, үүнээс 2021 оны 01 дүгээр сард улсын төсвөөс санхүүжилт орж ирээгүй тул</p> <p>1-р сарын тайлант үед улсын төсвөөс 0 төг, үүнээс: гүйцэтгэл 0 төг, хэмнэлт 0 төг байна гэж 2021.02.08-ны дотор оруулсан.</p> <p>1-р сарын тайлант үед орон нутгийн төсвөөс 1 397 000 төг, үүнээс: гүйцэтгэл 0 төг, хэмнэлт 1 397 000 төг байна гэж 2021.02.08-ны дотор оруулсан.</p> <p>2-р сарын тайлант үед улсын төсвөөс 23 386 800.0 төг, үүнээс: гүйцэтгэл 20 066 502.84 төг, хэмнэлт 3 320 297.16 төг байна гэж 2021.02.08-ны дотор оруулсан.</p> <p>2-р сарын тайлант үед орон нутгийн төсвөөс 2 794 000 төг, үүнээс: гүйцэтгэл 210 065.92 төг, хэмнэлт 2 583 934.08 төг байна гэж 2021.02.08-ны дотор оруулсан.</p> <p>3-р сарын тайлант үед улсын төсвөөс 37 405 300 төг, үүнээс: гүйцэтгэл 31 187 020 төг, хэмнэлт 6 218 280 төг байна гэж 2021.04.08-ны дотор оруулсан.</p> <p>3-р сарын тайлант үед орон нутгийн төсвөөс 4 191 000 төг, үүнээс: гүйцэтгэл 1 390 398.32 төг, хэмнэлт 2 800 601.68 төг байна гэж 2021.04.08-ны дотор оруулсан.</p> <p>4-р сарын тайлант үед улсын төсвөөс 48 623 800.0 төг, үүнээс: гүйцэтгэл 41 587 260 төг, хэмнэлт 7 036 540.00 төг байна гэж 2021.05.08-ны дотор оруулсан.</p> <p>4-р сарын тайлант үед орон нутгийн төсвөөс 5 588 000 төг, үүнээс: гүйцэтгэл 1 390 398.32 төг, хэмнэлт 4 197 601.68 төг байна гэж 2021.05.08-ны дотор оруулсан.</p>	
--	--	---	--



	<p>5-р сарын тайлант үед улсын төсвөөс 59 957 300.0 төг, үүнээс гүйцэтгэл 50 635 537.20 төг, хэмнэлт 9 321 762.80 төг байна гэж 2021.06.08-ны дотор оруулсан.</p> <p>5-р сарын тайлант үед орон нутгийн төсвөөс 6 785 000 төг, үүнээс гүйцэтгэл 1 390 398.32 төг, хэмнэлт 5 394 601.68 төг байна гэж 2021.06.08-ны дотор оруулсан.</p> <p>6-р сарын тайлант үед улсын төсвөөс 70 770 800 төг, үүнээс гүйцэтгэл 60 949 462.64 төг, хэмнэлт 9 821 337.36 төг байна гэж 2021.07.08-ны дотор оруулсан.</p> <p>6-р сарын тайлант үед орон нутгийн төсвөөс 7 982 000 төг, үүнээс гүйцэтгэл 2 629 527.24 төг, хэмнэлт 5 352 472.76 төг байна гэж 2021.07.08-ны дотор оруулсан.</p> <p>7-р сарын тайлант үед улсын төсвөөс 81 704 300 төг, үүнээс гүйцэтгэл 75 045 400 төг, хэмнэлт 6 658 900 төг байна гэж 2021.08.08-ны дотор оруулсан.</p> <p>7-р сарын тайлант үед орон нутгийн төсвөөс 9 154 000 төг, үүнээс гүйцэтгэл 2 704 877.24 төг, хэмнэлт 6 449 122.76 төг байна гэж 2021.08.08-ны дотор оруулсан.</p> <p>8-р сарын тайлант үед улсын төсвөөс 92 725 800 төг, үүнээс гүйцэтгэл 83 435 993 төг, хэмнэлт 9 289 993 төг байна гэж 2021.09.08-ны дотор оруулсан.</p> <p>8 -р сарын тайлант үед орон нутгийн төсвөөс 10 326 000 төг, үүнээс гүйцэтгэл 4 077 173.36 төг, хэмнэлт 6 248 826.64 төг байна гэж 2021.09.08-ны дотор оруулсан.</p> <p>9-р сарын тайлант үед улсын төсвөөс 115 187 300 төг, үүнээс гүйцэтгэл 101 397 157.67 төг, хэмнэлт 13 790 143.33 төг байна гэж 2021.10.08-ны дотор оруулсан.</p> <p>9 -р сарын тайлант үед орон нутгийн төсвөөс 15 998 000 төг, үүнээс гүйцэтгэл 5 455 409.48 төг, хэмнэлт 6 042 590.52 төг байна гэж 2021.10.08-ны дотор оруулсан.</p> <p>10-р сарын тайлант үед улсын төсвөөс 129 930 800 төг, үүнээс гүйцэтгэл 113 915 452.67 төг, хэмнэлт 16 015 347.33 төг байна гэж 2021.11.08-ны дотор оруулсан.</p> <p>10 -р сарын тайлант үед орон нутгийн төсвөөс 17 330 000 төг, үүнээс гүйцэтгэл 11 317 409.48 төг, хэмнэлт 6 012 590.52 төг байна гэж 2021.11.08-ны дотор оруулсан.</p>	
--	--	--



		<p>11-р сарын тайлант үед улсын төсвөөс 141 004 300 төг,үүнээс гүйцэтгэл 126 702 837.21 төг, хэмнэлт 14 301 462.79 төг байна гэж 2021.12.08-ны дотор оруулсан.</p> <p>11 -р сарын тайлант үед орон нутгийн төсвөөс 18 662 000 төг,үүнээс гүйцэтгэл 12 759 075.88 төг, хэмнэлт 5 902 924.12 төг байна гэж 2021.12.08-ны дотор оруулсан.</p> <p>4. “Тухай бүрт нь оруулах мэдээлэл”-ээс: - “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл”, “Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт” болон “Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн” бүлгийн “БУСАД” төрөлд 1,2 дугаар саруудад “ОРУУЛАХ МЭДЭЭЛЭЛ БАЙХГҮЙ” гэсэн мэдээлэл оруулсан.</p> <p>- “Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт” бүлгийн “ТӨСӨВ / ГҮЙЦЭТГЭЛ” төрөлд 1,2,3,4,5,6,7,8,9,10,11 дугаар сарын мэдээг заасан хуваарийн дагуу дараа сарын 08-ны дотор оруулсан.</p> <p>- “Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл” бүлгийн “Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт” төрөлд 1,2,3,4,5 ,6,7,8,9,10,11 дугаар саруудад “БАЙХГҮЙ” гэсэн мэдээлэл оруулсан.</p> <p>- “Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” бүлгийн “БУСАД” төрөлд 1,2,3,4,5 дугаар саруудад “ оруулах мэдээлэл байхгүй гэж холбогдох мэдээллийг оруулсан.</p> <p>- “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ” бүлгийн “ТӨСӨВ/ГҮЙЦЭТГЭЛ” төрөлд</p> <ul style="list-style-type: none">• 1 дүгээр сард нийт 0 төгрөгийн орлогын;• 2 дугаар сард 19 677 600 төгрөгийн орлогын;• 3 дугаар сард нийт 12 163 900 төгрөгийн орлогын;• 4 дүгээр сард 9 363 900 төгрөгийн орлогын;	
--	--	--	--



	<ul style="list-style-type: none">• 5 дугаар сард нийт 9 478 900 төгрөгийн орлогын;• 6 дугаар сард нийт 9 509 600 төгрөгийн орлогын ;• 7 дугаар сард нийт 9 509 600 төгрөгийн орлогын ;• 8 дугаар сард нийт 9 509 600 төгрөгийн орлогын ;• 9 дугаар сард нийт 9 509 600 төгрөгийн орлогын ;• 10 дугаар сард нийт 9 509 600 төгрөгийн орлогын ;• 11 дугаар сард нийт 9 509 600 төгрөгийн орлогын ;• 12 дугаар сард нийт 9 509 600 төгрөгийн орлогын ; мэдээллийг тус тус оруулсан	
Үнэлгээний дундаж хувь 100%		

4.2. ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО

- ✚ Манай байгууллага нь 2021 оны эхэнд Дарга, ахлах мэргэжилтэн-Чөлөөт бөхийн дасгалжуулагч, нягтлан бодогч-архив бичиг хэрэг, нийтийн биеийн тамир хариуцсан мэргэжилтэн-үйлчлэгч, спорт хариуцсан мэргэжилтэн, дасгалжуулагч гэсэн 7 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байна.
- ✚ Ажилтан, албан хаагчдын төрийн албаны ангилал, зэрэглэл, цалин урамшууллын өөрчлөлтийг тухай бүрт нь <https://hr.csc.gov.mn> сайтад шивж оруулан ажилласан.
- ✚ Тус байгууллагын ХАСХОМ гаргах 1 албан тушаалтан 2021 оны 02 дугаар сарын 15-с өмнө мэдүүлэг болон тайлангаа гарган НЗДТГ-н ТЗУХ-т хүргүүлж ажилласан.
- ✚ Байгууллагын ажилтан Б.Самбууням ЗГТА-БТСУХ , Биеийн тамирын дээд сургуультай хамтран зохион байгуулсан төгсөлтийн дараах сургалтанд амжилттай хамрагдсан ба НБТ-ын мэргэжилтэн Б.Мөнхзаяа ЗГТА-удирдлагын академын магистрантаар суралцаж байна.



Зорилт	№	Үйл ажиллагаа		Зорилт тот түвшин /тоо, хэмжээ, хувь/	Хүрсэн түвшин /хэрэгжил- тийн хувь, тоо хэмжээ/	Зарцуул сан хөрөнгө , эх үүсвэр гүйцэтгэ лээр/мян. төг/	Тайлбар
1. Хүний нөөцийг чадавхжуулах	1	Албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан гадаад, дотоодын сургалт	Дотоодын сургалтын тоо	3	3		Холбогдох байгууллагуудаас зохион байгуулсан 5 удаагийн цахим сургалтад 5 албан хаагчийг хамруулсан байна. ЗГТА-БТСУХ-с зохион байгуулж байгаа дасгалжуулагч нарын төгсөлтийн дараах нэгдсэн сургалтад мэргэжилтэн Б.Самбууням хамрагдаж байгаа ба салбар босоо тогтолцоонд шилжиж байгаатай холбоотойгоор албан хаагч бүрийг Төрийн албаны ерөнхий шалгалтанд хамрагдах чиглэл өгөөд байна.
			Албан хаагчдын хамрагдсан байдал	5	5		
			Гадаад сургалтад албан хаагчдын хамрагдсан байдал	2	1		
	2	Мэргэшсэн, туршлагатай хүний нөөцийг бүрдүүлэх	3 болон түүнээс дээш жил ажилласан мэргэшсэн боловсон хүчний үзүүлэлт	7	5		Тус байгууллага Дарга, 6 албан хаагчтай бөгөөд тэдгээрийн 5 албан хаагч нь 3 ба түүнээс дээш жил ажилласан. НБТ-ын мэргэжилтэн Б.Мөнхзаяа ЗГТА-удирдлагын академын магистрантаар суралцаж байна.
Хэсгийн дундаж: 50%							
2. Албан хаагчид	3	Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог	Шагнал, урамшуулалд хамрагдсан албан хаагчдын тоо	7			МУЗГ-н 2021 оны 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж байна.



йн нийг мий н бата лгаа г ханг ах.		хэрэгжүүлэх				
			Албан хаагчдын үйл ажиллагааны үнэлгээ, ажилласан жил, ур чадварыг харгалзан олгох нэмэгдэл, зэрэг дэв, шатлал ахиулах	4	4	Ур чадварын нэмэглэл 2 , спортын цол зэргийн нэмэгдэл 4, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл 4 албан хаагч авч байна
	4	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлсэн байдал	Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулга	7	7	Албан хаагчдын ажиллах нөхцөл байдлыг дүүргийн хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан төслийн удирдагч Ц.Алтанзагасд танилцуулж дэмжлэг хүсэлт гаргалаа.
			Албан хаагчдад сар бүр олгох хоол, унааны зардлыг нэмэгдүүлэх	7		Бүрэн авч байна.
	5	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг	7	7	Эрүүл мэндийн үзлэгт хамрагдаагүй байна. Корона вирусын PCR болон түргэвчилсэн шинжилгээг өгч байна.
			Албан хаагчдын хамрагдалт			
Хэсгийн дундаж: 50%						
Үнэлгээний дундаж хувь: 100%						



5. Бусад:

5.1. БУСАД БАЙГУУЛЛАГУУДАЙ ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААН

- Баянзүрх дүүргийн Ахмад мастеруудын салбар Зөвлөлтэй нягт хамтран ажиллаж байна.

-2021 онд Монголын Волейболын холбоо, Монголын Үндэсний сурын холбоо, Монголын Гимнастикийн холбоо, Монголын Олс таталтын холбоо, Монголын Хэт холын марафон гүйлтийн холбоо, Монголын Тэшүүрийн холбоо, Монголын Байт харвааны холбоо, Монголын боксын холбоо, Монголын Жүдо бөхийн холбоо, Монголын Чөлөөт бөхийн холбоо, Монголын Кураш бөхийн холбоо зэрэг холбоодтой дүүргийн аварга шалгаруулах тэмцээнүүдийг зохион байгуулахдаа арга зүйн зөвлөгөө авах, мөн уралдаан тэмцээн, нийтийн биеийн тамирын аливаа арга хэмжээний үеэр зохион байгуулагдах тэмцээн уралдааныг мэргэжлийн шүүгчээр шүүлгэх талаар хамтран ажиллаар төлөвлөөд байна.

- ЗГТА-БТСУХ болон НЭМҮТ- с зохион байгуулж буй "Эрүүл мэндийн цахим гүйлт-2021", "Идэвхтэй хөдөлгөөнийг дэмжих сарын аян" "Цахим гүйлтийн дэлхийн аварга", "Гимнастрада" арга хэмжээ, "Иргэдийн наадам-21" Биеийн тамирын арга хэмжээг зохион байгуулах ажилд хамтран оролцоод байна.

- Газар зохион байгуулалтын албатай хамтран дүүргийн ерөнхий боловсролын сургуулиудын заал болон гадна талбайн судалгааг гаргалаа.

ХЯНАСАН:
БИЕИЙН ТАМИР СПОРТЫН
ХОРООНЫ ДАРГА



С.ЭРДЭНЭБАТ

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:
БИЕИЙН ТАМИР СПОРТЫН
ХОРООНЫ АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Ю.БАТСАЙХАН